ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2026/158/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас:
Audit.mn
Хэнтий аймаг
Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан
Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn

Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа
Утас: 99088151 мэйл хаяг: arifin.audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026. 02. 24 № 261

танай ______________ -ны № ________________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БЭРХ ТОСГОНЫ
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.ДАВААСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “280 хүүхдийн цэцэрлэг”-ийн барилгын халаалт, сэлгэлт, холбоо дохиоллын 478,066.3 мянган төгрөгийн өртөг бүхий засварын ажлыг капиталжуулж, үндсэн хөрөнгийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны А/273 тушаалаар баталсан жагсаалтын дагуу эцэг эхээс бэлдүүлэх хичээлийн жилийн сургалтын хэрэглэгдэхүүн, ариун цэврийн хэрэгслийг хүлээн авсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитаар 10,998.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 10,714.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 284.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүллээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Батноров сумын Бэрх тосгоны Хүүхдийн цэцэрлэг нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний 14 зорилтын хүрээнд 42 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэл 85.0 хувиар дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

***2.1*** **Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **150,503,551.73** | **82,882,877.53** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **97,027,449.73** | **25,234,872.53** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **97,027,449.73** | **25,234,872.53** |
| **31210** | **Төгрөг** | **97,027,449.73** | **25,234,872.53** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 97,027,449.73 | 25,234,872.53 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **53,476,102.00** | **57,648,005.00** |
| **35400** | **Хангамжийн материал** | **53,476,102.00** | **57,648,005.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,250,000.00 | 1,490,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 18,511,310.00 | 18,605,210.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,886,000.00 | 3,586,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 7,039,292.00 | 4,543,645.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 24,789,500.00 | 29,422,350.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,359,648,438.69** | **1,763,869,648.39** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,359,648,438.69** | **1,763,869,648.39** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,342,702,438.69** | **1,746,923,648.39** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,643,456,296.30 | 2,119,095,598.30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (363,947,500.08) | (426,531,896.16) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 93,816,094.70 | 89,562,631.40 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (54,639,778.47) | (52,931,325.83) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,784,881.44 | 22,343,437.56 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (31,145,506.20) | (20,510,325.88) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 38,031,588.00 | 36,784,688.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (16,653,637.00) | (20,889,159.00) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **16,946,000.00** | **16,946,000.00** |
| 39301 | Програм хангамж | 250,000.00 | 250,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (250,000.00) | (250,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,946,000.00 | 16,946,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,510,151,990.42** | **1,846,752,525.92** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,510,151,990.42** | **1,846,752,525.92** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,510,151,990.42** | **1,846,752,525.92** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 186,315,432.10 | 186,315,432.10 |
| 51101 | Өмч: - төрийн | 186,315,432.10 | 186,315,432.10 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **414,829,633.95** | **751,430,169.45** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 446,331,914.26 | 414,829,633.95 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (31,502,280.31) | 336,600,535.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 909,006,924.37 | 909,006,924.37 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,510,151,990.42** | **1,846,752,525.92** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,049,827,948.50** | **1,580,892,002.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **36,118,548.50** | **488,101,302.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **36,118,548.50** | **488,101,302.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 36,118,548.50 | 488,101,302.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 35,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 36,118,548.50 | 488,066,302.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 0.0 | **1,092,790,700.00** |
| 1221 | Тусламжийн орлого | 0.0 | 924,110,800.00 |
| 12211 | Хандив тусламж /дотоод/ | 0.0 | 924,110,800.00 |
| 122111 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0.0 | 924,110,800.00 |
| 122111 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0.0 | 168,679,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,013,709,400.00** | **0.0** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **853,789,500.00** | **0.0** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 853,789,500.00 | 0.0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **159,919,900.00** | **0.0** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 159,919,900.00 | 0.0 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,081,330,228.81** | **1,244,291,466.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,081,330,228.81** | **1,244,291,466.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,073,849,228.81** | **1,243,065,745.45** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **648,220,913.47** | **792,645,955.95** |
| 210101 | Үндсэн цалин | 413,213,227.23 | 486,679,767.33 |
| 210102 | Нэмэгдэл | 215,810,017.03 | 260,854,006.19 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 11,425,000.00 |
| 210104 | Урамшуулал | 19,197,669.21 | 33,687,182.43 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **79,553,051.57** | **92,147,221.25** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,943,154.29 | 61,859,479.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,558,954.50 | 7,735,387.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,279,527.46 | 3,867,443.77 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,130,631.86 | 3,705,826.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,640,783.46 | 14,979,083.89 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **153,950,214.00** | **159,454,178.95** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,426,721.50 | 16,582,106.45 |
| 210302 | Түлш, халаалт | 136,585,284.00 | 136,296,424.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,938,208.50 | 6,575,648.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **79,996,302.00** | **87,599,847.00** |
| 210502 | Хоол, хүнс | 79,996,302.00 | 87,599,847.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,794,586.00** | **5,445,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 8,794,586.00 | 5,445,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **943,800.00** | **3,752,500.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 943,800.00 | 3,752,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **102,390,361.77** | **102,021,042.30** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,929,150.00 | 11,769,120.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 471,050.00 | 6,406,830.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 78,990,161.77 | 83,845,092.30 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,481,000.00** | **1,225,721.05** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **7,481,000.00** | 0.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,481,000.00 | 0.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.0 | **1,225,721.05** |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 0.0 | 1,225,721.05 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(31,502,280.31)** | **336,600,535.50** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(31,502,280.31)** | **336,600,535.50** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,013,709,400.00** | **1,092,825,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 0.0 | **35,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 0.0 | 35,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 0.0 | 35,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.0 | 35,000.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 0.0 | **1,092,790,700.00** |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0.0 | 924,110,800.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0.0 | 924,110,800.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | 0.0 | 924,110,800.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | 0.0 | 168,679,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,013,709,400.00** | 0.0 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **853,789,500.00** | 0.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 853,789,500.00 | 0.0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **159,919,900.00** | 0.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 159,919,900.00 | 0.0 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **999,065,965.04** | **1,164,618,277.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **999,065,965.04** | **1,164,618,277.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **991,584,965.04** | **1,163,392,556.15** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **648,220,913.47** | **792,645,955.95** |
| 210101 | Үндсэн цалин | 413,213,227.23 | 486,679,767.33 |
| 210102 | Нэмэгдэл | 215,810,017.03 | 260,854,006.19 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 11,425,000.00 |
| 210104 | Урамшуулал | 19,197,669.21 | 33,687,182.43 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **79,553,051.57** | **92,147,221.25** |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,943,154.29 | 61,859,479.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,558,954.50 | 7,735,387.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,279,527.46 | 3,867,443.77 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,130,631.86 | 3,705,826.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,640,783.46 | 14,979,083.89 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **147,919,900.00** | **159,454,178.95** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,426,721.50 | 16,582,106.45 |
| 210302 | Түлш, халаалт | 130,554,970.00 | 136,296,424.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,938,208.50 | 6,575,648.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **77,111,200.00** | **85,104,200.00** |
| 210502 | Хоол, хүнс | 77,111,200.00 | 85,104,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **12,000,000.00** | **8,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 12,000,000.00 | 8,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,504,900.00** | **4,012,500.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,504,900.00 | 4,012,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **24,275,000.00** | **22,028,500.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,794,200.00 | 15,163,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,480,800.00 | 6,865,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,481,000.00** | **1,225,721.05** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **7,481,000.00** | 0.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,481,000.00 | 0.0 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 0.0 | **1,225,721.05** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.0 | 1,225,721.05 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **14,643,434.96** | **(71,792,577.20)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **4,010,600.00** | 0.0 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,010,600.00** | 0.0 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 4,010,600.00 | 0.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | 4,010,600.00 | 0.0 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(4,010,600.00)** | 0.0 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **10,632,834.96** | **(71,792,577.20)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **86,394,614.77** | **97,027,449.73** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **97,027,449.73** | **25,234,872.53** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **186,315,432.10** | **909,006,924.37** | **383,327,353.64** | **1,478,649,710.11** |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **186,315,432.10** | **909,006,924.37** | **383,327,353.64** | 1,478,649,710.11 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | (31,502,280.31) | (31,502,280.31) |
| 10 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 186,315,432.10 | 909,006,924.37 | 414,829,633.95 | 1,510,151,990.42 |
| 11 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **186,315,432.10** | **909,006,924.37** | **414,829,633.95** | **1,510,151,990.42** |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **186,315,432.10** | **909,006,924.37** | **414,829,633.95** | **1,510,151,990.42** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 336,600,535.50 | 336,600,535.50 |
| 20 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **186,315,432.10** | **909,006,924.37** | **751,430,169.45** | **1,846,752,525.92** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **1,093,671,200.00** | **1,091,599,978.95** | **(2,071,221.05)** | **99.8** |
| **12** | **Татварын бус орлого** | **1,093,671,200.00** | **1,091,599,978.95** | **(2,071,221.05)** | **99.8** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **35,000.00** | **35,000.00** | **-** | **100.0** |
| **120010** | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 35,000.00 | 35,000.00 | - | 100.0 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 924,956,300.00 | 924,110,800.00 | (845,500.00) | 99.9 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | 924,956,300.00 | 924,110,800.00 | (845,500.00) | 99.9 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 168,679,900.00 | 167,454,178.95 | (1,225,721.05) | 99.3 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | 168,679,900.00 | 167,454,178.95 | (1,225,721.05) | 99.3 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,180,106,400.00** | **1,163,392,556.15** | **-16,713,843.85** | **98.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,180,106,400.00** | **1,163,392,556.15** | **-16,713,843.85** | **98.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,180,106,400.00** | **1,163,392,556.15** | **-16,713,843.85** | **98.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **800,251,400.00** | **792,645,955.95** | **-7,605,444.05** | **99** |
| 210101 | Үндсэн цалин | 489,086,100.00 | 486,679,767.33 | -2,406,332.67 | 99.5 |
| 210102 | Нэмэгдэл | 279,697,100.00 | 260,854,006.19 | -18,843,093.81 | 93.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 11,425,000.00 | 11,425,000.00 | |
| 210104 | Урамшуулал | 31,468,200.00 | 33,687,182.43 | 2,218,982.43 | 107.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **99,067,800.00** | **92,147,221.25** | **-6,920,578.75** | **93** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,193,800.00 | 61,859,479.44 | -5,334,320.56 | 92.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,968,600.00 | 7,735,387.17 | -233,212.83 | 97.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,984,200.00 | 3,867,443.77 | -116,756.23 | 97.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,984,200.00 | 3,705,826.98 | -278,373.02 | 93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,937,000.00 | 14,979,083.89 | -957,916.11 | 94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **160,679,900.00** | **159,454,178.95** | **-1,225,721.05** | **99.2** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,960,000.00 | 16,582,106.45 | 4,622,106.45 | 138.6 |
| 210302 | Түлш, халаалт | 143,469,900.00 | 136,296,424.50 | -7,173,475.50 | 95 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,250,000.00 | 6,575,648.00 | 1,325,648.00 | 125.3 |
| **2105** | **Нормативт зардал** | **85,949,700.00** | **85,104,200.00** | **-845,500.00** | **99** |
| 210502 | Хоол, хүнс | 85,949,700.00 | 85,104,200.00 | -845,500.00 | 99 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,000,000.00** | **8,000,000.00** | **0** | **100** |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 8,000,000.00 | 0 | 100 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,012,500.00 | 4,012,500.00 | 0 | 100 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,012,500.00 | 4,012,500.00 | 0 | 100 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **22,145,100.00** | **22,028,500.00** | **-116,600.00** | **99.5** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,279,600.00 | 15,163,000.00 | -116,600.00 | 99.2 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,865,500.00 | 6,865,500.00 | -116,600.00 | 100 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | **-86,435,200.00** | **-71,792,577.20** | -116,600.00 | **92.5** |
| 9 | АЛДАГДЛЫГ НӨХӨХ ЭХ ҮҮСВЭР | **86,435,200.00** | **71,792,577.20** | -116,600.00 | **99.9** |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 86,435,200.00 | 71,792,577.20 | -116,600.00 | 99.9 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **97,027,449.73** | **97,027,449.73** | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **25,234,872.53** | **25,234,872.53** | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **28** | **28** | **-** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19 | 19 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 8 | - | 100.0 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,714.4 мянган төгрөгийн 3 зөрчил[1] илэрснээс, 10,714.4 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй зөрчилд 1 зөвлөмж тус тус хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 10,717.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1 Албан шаардлага

1. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аль түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 2 ажилтанд 15-25 хувиар, цэцэрлэгийн эрхлэгчид 20 хувиар тус тус тооцож 10,714.4 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь "Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн, Биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

2. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.1-д "бие даасан байх", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 15.2- т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн, Биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

### 3.2 Зөвлөмж

**1.** Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт-1:** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 20 нэр төрлийн (анхны өртөг 22,169.3 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1."Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

**<u>Өгсөн зөвлөмж</u>:** Эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж, шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аль түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 2 ажилтанд 15-25 хувиар, цэцэрлэгийн эрхлэгчид 20 хувиар тус тус тооцож 10,714.4 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон | 1 | 10,714.4 | 1 | | 1 | 10,714.4 | | | | | | |
| Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байгаа | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 20 нэр төрлийн (анхны өртөг 22,169.3 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй | 1 | - | | | | | 1 | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Дүн** | **3** | **10,714.4** | | | **2** | **10,714.4** | **1** | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |